

**ЦЭРГИЙН АНГИ, БАЙГУУЛЛАГАД ҮЙЛДЭГДЭЖ БУЙ ЦЭРГИЙН АЛБАНЫ
ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ: ХҮНИЙ АМЬ НАС, ЭРҮҮЛ
МЭНДЭД УЧИРСАН ХОХИРЛЫН АСУУДАЛ**

RESULTS ANALYSIS OF THE PROBLEM OF CRIMES AGAINST MILITARY SERVANTS
WHICH DAMAGE HUMAN LIFE AND HEALTH IN MILITARY UNITS AND BRANCHES

Г.Мэндбаяр

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Дотоодын цэргийн
албаны тэнхимийн ахлах багш, дэд хурандаа*

Товч агуулга: Сүүлийн жилүүдэд Зэвсэгт хүчин, батлан хамгаалах салбар, бусад төрөл мэргэжлийн цэргийн анги, байгууллагуудад хүний эрхийн зөрчлүүд үүсээд байгаатай холбогдуулан, цэргийн анги байгууллагын албаны зохион байгуулалт, албан үүрэг гүйцэтгэж байхдаа албаны журам зөрчсөн, гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээнд бүртгэсэн зарим хүний эрхийн зөрчлийн хэлбэр, нэр томьёо, гарсан гэмт хэрэг, зөрчлийн бүртгэлд, дүн шинжилгээ хийж нөхцөл байдлыг судлан үзэж энэхүү өгүүлэлдээ үүсэж буй хүний эрхийн зөрчлүүд талаар авч үзлээ.

Abstract: In recent years, human rights violations have been emerging in the Armed Forces, the defense sector, and other specialized military units and organizations. In connection with this, the article analyzes the forms, terminology, and recorded cases of human rights violations, crimes, and offenses that have been documented in the statistical records of offenses committed while carrying out official duties and violating regulations in the organizational structure of military units. The article examines the situation regarding these emerging human rights violations.

Түлхүүр үгс: Цагдаагийн байгууллага, Зэвсэгт хүчин, Хилийн цэрэг, Дотоодын цэрэг, Хугацаат цэргийн алба хаагч, Цэргийн алба хаагч

Keywords: Police, Armed Forces, Border Guard, Home Guard, Conscript, Military Service

Дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

“Цэргийн жинхэнэ алба хаагч” гэж цэргийн байгууллагад цэргийн алба биеэр хааж байгаа монгол улсын иргэнийг (хууль, Цэргийн албаны тухай хууль 3 дугаар зүйл 3.1.5 дэх хэсэг, 2016)

“Хугацаат цэргийн алба хаагч” гэж цэргийн албанд татагдан цэргийн байгууллагад энэ хуулиар тогтоосон хугацаанд цэргийн жинхэнэ албыг биеэр хааж байгаа иргэнийг; (хууль Ц. а., Цэргийн албаны тухай хууль 3 дугаар зүйл 3.1.9 дэх хэсэг, 2016)

“Цэргийн гэрээт алба хаагч” гэж цэргийн байгууллагад сайн дураар гэрээгээр цэргийн жинхэнэ алба хааж байгаа иргэнийг; (хууль Ц. а., Цэргийн албаны тухай хууль 3 дугаар зүйл 3.1.9 дэх хэсэг, 2016)

Монгол Улсын иргэн нь Үндсэн хуульд зааснаар эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах үндсэн үүрэгтэй. (хууль М. У., 1992)

Цэргийн албаны тухай хуульд цэргийн албыг зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагад Монгол Улсын иргэн цэргийн алба хаах үндсэн үүргийг биеэр гүйцэтгэх эсхүл цэргийн бүртгэлд байх гэж тодорхойлсон.

Мөн Монгол Улсын иргэн цэргийн байгууллагад цэргийн алба хаах үүргийг биеэр гүйцэтгэхийг "цэргийн жинхэнэ алба" гэж, Цэргийн байгууллагад цэргийн алба биеэр хааж байгаа Монгол Улсын иргэнийг "цэргийн жинхэнэ алба хаагч" гэж,

Монгол Улсын иргэн цэргийн байгууллагад офицерын албан тушаалд цэргийн жинхэнэ алба хаахыг "офицерын алба" гэж;

Монгол Улсын иргэн цэрэгт бүртгэлтэй мэргэжлээр цэргийн байгууллагад ахлагчийн албан тушаалд цэргийн жинхэнэ алба хаахыг "ахлагчийн алба" гэж,

Цэргийн албанд татагдан цэргийн байгууллагад энэ хуулиар тогтоосон хугацаанд цэргийн жинхэнэ албыг биеэр хааж байгаа иргэнийг "хугацаат цэргийн алба хаагч" гэж,

Цэргийн байгууллагад сайн дураар гэрээгээр цэргийн жинхэнэ алба хааж байгаа иргэнийг "цэргийн гэрээт алба хаагч" гэж тус тус тодорхойлсон. (хууль ц. а., 2016)

Цэргийн албаны тухай хуульд зааснаар цэргийн албыг Монгол Улсын 18-27 насны иргэн хаах үүрэгтэй (хууль Ц. а., Цэргийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйл, 2016) бөгөөд дараах төрөлтэй байна. Үүнд:

- Хугацаат цэргийн албыг биеэр хаах;
- Оюутан-цэрэг сургалтад хамрагдах;
- Цэргийн албыг дүйцүүлэх.

Хугацаат цэргийн албыг биеэр хаах гэдэг нь цэргийн албанд татагдан, 12 сарын хугацаанд цэргийн байгууллагад алба хаахыг хэлэх бөгөөд биеэр хаах насны дээд хязгаар 27 байна.

Хугацаат цэргийн албанд татагдсан Монгол Улсын иргэд зэвсэгт хүчин, хилийн болон дотоодын цэрэгт алба хааж, хуулиар тогтоосон чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Зэвсэгт хүчин, дотоодын цэргийн анги, байгууллагад алба хааж буй хугацаат цэргийн алба хаагч нь хоногийн харуул манаа, тусгай ажиллагаа, ангийн байрлалаас гадагш явах түр чөлөөтэй болон эмнэлэгт хэвтэн эмчлүүлснээс бусад тохиолдолд байнгын бэлтгэл сургуулилалт, бэлэн байдлыг хангах үндсэн чиг үүрэгтэй.

Хилийн цэрэгт алба хааж байгаа хугацаат цэргийн алба хаагч нь Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг хангах, хил хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэхэд биечлэн оролцож, хилийн анги, заставуудад харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэж, хилчний зарим эрх зүйн баталгаагаар хангагддаг онцлогтой юм.

Цэргийн албаны онцлогоос шалтгаалан алба хаагчийн эрхийн хязгаарлалт нь ихэвчлэн цэргийн анги, байгууллагын журмыг чандлан сахих, улс төрийн төвийг сахисан бодлого баримтлах, байлдааны үйл ажиллагааны үр ашигт байдлыг хангах, төрийн болон албаны нууц мэдээллийг хамгаалах, тушаал биелүүлэх, цэргийн байгууллагын шатлан захирах бүтцийг хадгалахтай холбоотой байдаг.

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар албан үүргээ гүйцэтгэж байгаа цэргийн жинхэнэ алба хаагч, цэргийн дайчилгаатай сургууль, цугларалтад оролцож байгаа цэргийн бэлтгэл үүрэгтэнд хамаардаг (хууль Ц. а., 2016) байна.

Цэргийн алба хаагч ангийн байрлал, эсхүл ангийн байрлалын гадна албан үүрэг, байлдааны жижүүрлэлт, харуул, хоногийн манааны үүрэг гүйцэтгэх, ажилдаа ирэх, буцахыг албан үүргээ гүйцэтгэж байгаад тооцохоос гадна доор дурдсан нөхцөлийг албан үүргээ гүйцэтгэж байгаад тооцно:

1. Гадаад улс болон орон нутагт албан томилолтоор ажиллах;
2. Дотоод, гадаадын цэргийн сургуульд суралцах;
3. Цэргийн сургалт бэлтгэл, дайчилгаатай сургууль, цугларалтад оролцох;
4. Улсын хил, онц чухал объектыг хамгаалах;
5. Орон нутгийн хамгаалалтын арга хэмжээнд оролцох;

6.Хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчныг гамшгийн аюулаас аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, хорио цээрийн дэглэмийг сахиулах;

7.Тэсэрч дэлбэрэх зүйл, цацраг идэвхт болон химийн хорт бодисыг аюулгүй болгох, устгах;

8.Аливаа хөнөөх хэрэгслийн хөнөөлөөс хүн ам, мал, амьтан, эд хөрөнгийг аврах, хор уршгийг арилгах;

9.Энхийг дэмжих ажиллагаанд оролцох;


10.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох;



11.Томилгоот бусад үүрэг гүйцэтгэх.

Цэргийн албанд татагдагч цэрэг татлагын байрнаас цэргийн анги, байгууллагад хүрэх, хугацаат цэргийн албанаас бэлтгэлээр халагдсан иргэн цэргийн анги, байгууллагаас орон нутагт хүрэх хугацааг албан үүргээ гүйцэтгэж байгаад тооцдог (хууль Ц. а., Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйл, 2016) байна.

Гэмт хэргийн улмаас 2013-2023 онд хохирсон төрийн цэргийн байгууллагын алба хаагчдын судалгаа

Төрийн цэргийн байгууллага	Он											
	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	Нийт
Зэвсэгт хүчин	45	36	63	59	88	93	91	69	58	123	92	817
Хилийн цэрэг	23	5	26	24	24	39	38	23	31	50	42	325
Дотоодын цэрэг	6	1	-	1	1	4	2	11	8	13	10	57
Онцгой байдал	16	19	22	27	27	23	43	30	23	55	46	331
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага	24	29	46	35	29	56	54	56	43	48	58	478
Бүгд	114	90	157	146	169	215	228	189	163	289	248	2008





Цэргийн анги, байгууллага дахь хүний эрхийн төлөв байдлыг тодорхойлоход цэргийн алба хаагчийн амь нас, эрүүл мэнд хохирсон болон хүнлэг бус харьцсан гэмт хэрэг, зөрчлийг бүртгэх нэгдсэн тогтолцоо чухал үүрэгтэй бөгөөд эдгээрийг нэгтгэн харуулсан мэдээллийн сан одоогоор аль ч байгууллагад байхгүй байна.

Тиймээс ХЭҮК-т холбогдох байгууллагуудаас ирүүлсэн баримт бичиг, социологийн судалгаанд үндэслэн дүрмийн бус харьцааны нөхцөл байдлыг тодорхойллоо.

Цэргийн анги, салбарт цэргийн дүрмийн бус харьцааны эрх зүйн зөрчлийн улмаас хугацаат цэргийн алба хаагч амь нас, эрүүл мэндээрээ хохирсоор байна.

Сүүлийн 10 жилийн хугацаанд цэргийн анги, байгууллагад 468 эрх зүйн зөрчил буюу гэмт хэрэг, сахилгын зөрчил бүртгэгдсэний 242 нь зэвсэгт хүчинд, 217 нь хилийн цэрэгт, 9 нь дотоодын цэрэгт хамааралтай байна. (хүрээлэн, 2021)




Зэвсэгт хүчний хэмжээнд сүүлийн 10 жилийн хугацаанд бүртгэгдсэн 242 зөрчлийн 144 нь гэмт хэргийн шинжтэй, 98 нь сахилгын зөрчил байна. Эдгээрээс хугацаат цэргийн алба хаагчийн амь нас хохирсон 7 тохиолдлын 3 нь усанд живсэн, 2 нь хөдөлмөр хамгааллын аюулгүй байдал алдагдсанаас, 1 нь хүнийг алах гэмт хэргийн улмаас, 1 нь амиа хорлосон байна.

Харин энэ хугацаанд 27 хугацаат цэргийн алба хаагч гэмт хэргийн улмаас эрүүл мэндээрээ хохирчээ.


Дээр дурдсан 98 сахилгын зөрчлийн 41 буюу 41.8 хувь нь дүрмийн бус харьцаа, 24 буюу 24.4 хувь нь хугацаат цэргийн албанаас оргон зайлсан зөрчил байна. (хүрээлэн, 2021)

Зэвсэгт хүчний хэмжээнд сүүлийн 10 жилийн хугацаанд хугацаат цэргийн алба хаагчийн амь нас, гэмт хэргийн улмаас эрүүл мэндээрээ хохирсон.



Хил хамгаалах байгууллагын хэмжээнд 217 гэмт хэрэг, зөрчилд 298 алба хаагч холбогдон шалгагдаж, 37 цэргийн алба хаагчийн амь нас хохирсны 13 нь хугацаат цэргийн алба хаагч, 107 цэргийн алба хаагч дүрмийн бус харьцааны зөрчил гаргасны 36 нь хугацаат


цэргийн алба хаагч байсан бол цэргийн албанаас оргон зайлах гэмт хэрэгт 31 хугацаат цэргийн алба хаагч холбогджээ. (комисс Х. э., Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний 21 дэх илтгэл, 2022)



Дотоодын цэргийн анги, байгууллагад 2012-2013 онд 1 гэмт хэрэг, 8 зөрчил бүртгэгдсэнээс хүний эрүүл мэнд хохирсон 2, цэргийн албанаас оргон зайлах 1, бусад хэлбэрийн 5 зөрчил байна.

ХЭҮК-оос 2011-2022 оны хооронд цэргийн алба хаагчтай холбоотой шийдвэрлэгдсэн болон мөрдөн байцаалтын 124 хавтаст хэргийн материалд дүн шинжилгээ хийхэд хүний амь нас хохирсон 15, цэргийн алба хаагчийн эрүүл мэндэд хохирол учруулсан 77, цэргийн албанаас оргон зайлсан 30 тохиолдол байв.

Үүнээс хугацаат цэргийн алба хаагчийн амь нас хохирсон 9, эрүүл мэнд хохирсон 44, оргон зайлсан 14 тохиолдол байна. (комисс Х. э., Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний 21 дэх илтгэл, 2022)



ХЭҮК-оос 2021 онд хийсэн хэргийн түүвэр судалгаагаар 2009-2021 оны хооронд цэргийн анги, байгууллагад хүний амь нас хохирсон 15 тохиолдлын 8 нь хугацаат цэргийн алба хаагчийн амь нас хохирсон, 1 нь хугацаат цэргийн алба хаагч захирагч даргынхаа амь насыг хохироосон байгаагаас 2 нь зодож цохисон, 4 нь галт зэвсэг ашигласан, 1 нь амьсгал

боогдуулсан, 3 нь өөрийгөө боомилсон гэмт хэрэг байгаа нь цэргийн алба хаагчийн дүрмийн бус харьцаанаас үүдэлтэй байна.

Харин цэргийн алба хаагчийн эрүүл мэнд, эрх чөлөөнд халдсан 77 тохиолдлоос 44 хугацаат цэргийн алба хаагчдын эрүүл мэнд хохирсон байх бөгөөд эдгээрийн 18 нь офицер, ахлагчийн, 25 нь хугацаат цэргийн алба хаагчийн хоорондын дүрмийн бус харьцаанаас үүдэлтэй байжээ. Үйлдлийн аргаар нь авч үзвэл 56 нь зодож цохих байдлаар хүч хэрэглэсэн, 8 нь галт зэвсэг ашигласан, 8 нь хутга хэрэглэсэн, 2 нь зодохоос бусад хэлбэрээр үйлдэгдсэн бол 3 нь болгоомжгүй байдлаас үйлдэгджээ.

Цэргийн алба хаагчдын дүрмийн бус харьцааны зөрчил нь бие махбодын, сэтгэл санааны, эдийн засгийн, сахилгын дүрэмд заагдаагүй арга хэмжээ авах, цэргийн дүрэмд заагаагүй ажил хийлгэх хэлбэрээр илэрч байгаагаас гадна бэлгийн хүчирхийллийн шинжтэй үйлдлүүд цөөнгүй тохиолдож байна.

Цэргийн нийтлэг дүрэмд заасан сахилгын шийтгэл хүлээхээс гадна дүрэмд заагаагүй шийтгэл хүлээж байгаа нь судалгаагаар тогтоосон. Тухайлбал: ажил хийлгэх (ариун цэврийн өрөө цэвэрлэх, хог цэвэрлэх, аж ахуйн ажил хийлгэх, гарын доорх материалаар эд зүйл хийх), биеийн хүч, тэсвэр тэвчээрийн дасгал, сургуулилалт хийлгэх (гүйх, суниах, гимнастик хийх, номхон зогсох, элэг дөрвөөр явах, ялаа алах, галуун цуваагаар явах, цэргийн 16 тоот дасгалын 2 болон 14 тоот байрлалаар удаан хугацаанд зогсоох, буу өргүүлж зогсоох), ээлжийн бус харуул манаанд гарах, улируулах, сэтгэл зүйн шинжтэй шийтгэл (бусдын өмнө загнах, хэл амаар доромжлох), өрөөнд хорих зэрэг шийтгэлийг нэрлэжээ.

Монгол Улсын хууль тогтоомж, Цэргийн нийтлэг дүрмүүд, Цэргийн тангараг, цэргийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, ангийн дотоод журмыг зөрчсөн, захирагчийн хууль ёсны тушаалыг биелүүлээгүй цэргийн алба хаагчийн үйлдэл, эс үйлдэхүйг сахилгын зөрчилд тооцно гэж тодорхойлсон.

Монгол Улсын хууль тогтоомж, Цэргийн нийтлэг дүрмүүдийг чанд мөрдүүлэх, гэмт хэрэг, зөрчил, дутагдлаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, арилгах, засаж залруулах, цаашид давтан гаргуулахгүй байх зорилгоор сахилгын зөрчил гаргасан цэргийн алба хаагчийн үйлдэл, эс үйлдэхүйг тогтоож, үндэслэл бүхий нотлох баримтыг үндэслэн эрх бүхий албан тушаалтан сахилгын шийтгэл ногдуулна.

Цэргийн алба хаагчид ногдуулах сахилгын шийтгэл нь зөрчлийн шинж, учруулсан хохирол, үйлдэл, эс үйлдэхүйд нь тохирсон байна. (зарлиг, 2022)

Хугацаат цэргийн албаны түрүүч, байлдагч, цэргийн сургуулийн сонсогч нарт дараах төрлийн сахилгын шийтгэлийг ногдуулдаг байна. (зарлиг М. у., 2022)

- 1.өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах;
- 2.бие бүрэлдэхүүнд зарлах хэлбэрээр нээлттэй сануулах;
- 3.түр чөлөө авах эрхийг хязгаарлах;
- 4.орон нутгийн чөлөө авах эрхийг хязгаарлах;
- 5.гурав хүртэл хоног тусгаарлан саатуулах;
- 6.албан тушаалаас бууруулах;
- 7.цэргийн цолыг хураах гэж цэргийн сахилгын дүрэмд тусгасан байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлд, Албадан хөдөлмөрлүүлэхийг хориглох зүйл заалтуудыг тусгасан байдаг. Мөн хуулийн 8 дугаар зүйл зүйлийн 8.3, 8.3.2-г.Дараах ажил, үйлчилгээ албадан хөдөлмөрлүүлэхэд хамаарахгүй гэдэгт хугацаат цэргийн албан хаагчийн хийж гүйцэтгэж байгаа цэргийн зориулалттай ажил, үйлчилгээ гэж тодорхойлсон байна.

Хугацаат цэргийн албан хаагчийн хийж гүйцэтгэж байгаа цэргийн зориулалттай ажил, үйлчилгээг гэдгийг бусад эрх зүйн зохицуулалтад тусгаагүй байна.

№	Дүрмийн бус харьцааны хэлбэр	2006 он	2021 он	Өсөлт бууралтын хувь
1	Ялгаварлан гадуурхах	22,7	11,4	-11,3
2	Заналхийлэх сүрдүүлэх	23,2	4,6	-18,6
3	Хүч хэрэглэх, зодох	22,5	11	-11,5
4	Мөнгө, эд зүйл шаардах	23,5	3,1	-20,4
5	Доромжлох, хараах, нэр хоч өгөх	27,9	13	-14,9
6	Бусдаар зодуулах	14,9	2,1	-12,8
7	Дүрмийн бус шийтгэл хүлээлгэх	20,3	33,3	13

Судалгаанд оролцсон хугацаат цэргийн алба хаагчдаас тэдгээрийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан, эсхүл учруулж болзошгүй, ядраах, өвдөлт мэдрүүлэхэд чиглэгдсэн цэргийн дүрмийн бус аливаа үйлдлийн талаар тодруулахад дараах үйлдлүүдийг нэрлэжээ.

Үүнд: цохих, зодох, унтлагын цагаар босгож гүйлгэх, хөл нүцгэн гаргах, бэлтгэл сургуулилалтын цагийг уртасгах, хугацаагүй жагсаалын бэлтгэл хийлгэх, халуун үед эсхүл өдрийн турш удаан хугацаагаар номхон командтай зогсоох, бууны гох буцаах, гуяны махтай цохих, ус өгдөггүй эсвэл бөөлжтөл хоол, ус ихээр өгөх, хооллосны дараа сунгалгах, аранз үүрүүлж гүйлгэх, нударга дээр нь гар тулж хэвтүүлэн цээж, бөгс рүү нь өшиглөх, өвдөлт мэдрүүлэхэд чиглэгдсэн үйлдэл хийх зэрэг бие махбодын шинжтэй дүрмийн бус харьцаа байдаг гэдгийг дурджээ.

Мөн “Удирдах албан тушаалтан хувийн ажил”-аа хийлгэх “хүссэн үед нь бие засуулахгүй байх”, “цагт нь унтуулахгүй байх”, “унтлагын цагаар сэрээх” гэсэн зөрчлүүд илэрч байна.

Төрийн тусгай алба хаагчдын нэгдсэн эмнэлгээс гаргасан төрийн тусгай алба хаагчид болон гэрээт, хугацаат цэргийн алба хаагчдын дунд зонхилон тохиолдож буй өвчин, эмгэгийн байдлын судалгааг дараах байдлаар харуулав.

**ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИД АЛБАН ХААХ ХУГАЦААНДАА ДАРААХ ӨВЧЛӨЛӨӨС
ШАЛТГААЛАН ХУГАЦААНААС ӨМНӨ ХАЛАГДСАН БАЙДАЛ**

	Төрөл бүрийн гэмтлүүд
	Үрэвсэлт өвчнүүд, тэдгээрийн хүндрэл (хамар дайвар хөндийн)
	Хоол боловсруулах замын шархлаат өвчнүүд
	Сэтгэцийн эмгэгүүд

**ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ХААГЧИД ХУГАЦААНААС ӨМНӨ АЛБАНААС ЧӨЛӨӨЛӨГДСӨН
БАЙДАЛ**

	Хорт хавдар
	Гэмтэл
	Чихрийн шижин, түүний хүндрэлүүд
	Тархины хүнд хэлбэрийн цус харвалтууд
	Мэдрэлийн ёзоор дарагдлын хам шинжүүд
	Элэгний хатуурал, түүний хүндрэлүүд

**ЦЭРЭГ ХАЛАХ ТАТАХ ТӨВД ЦЭРГИЙН НАСНЫ ЗАЛУУС ДАРААХ ӨВЧИН ЭМГЭГИЙН
УЛМААС ЦЭРГИЙН АЛБАНД ТЭНЦЭЭГҮЙ БАЙДАЛ**

	Сэтгэцийн эмгэгүүд (бие хүний болон зан төрөхийн органик эмгэгүүд)
	Дунд чихний үрэвсэл, сонсгол бууралт
	Хараа бууралт, алдалт
	Зүрх судасны эмгэг, таргалалт (Артерийн даралт ихсэх өвчин, зүрхний I төрөлхийн болон олдмол гажууд г.м)
	Шүд, эрүү нүүрний эмгэг, идээт өвчнүүд

**АЙМАГ, ДҮҮРГИЙН ЭМТӨВД ЦЭРГИЙН НАСНЫ ЗАЛУУС ДАРААХ ӨВЧИН ЭМГЭГИЙН
УЛМААС ЦЭРГИЙН АЛБАНД ТЭНЦЭЭГҮЙ БАЙДАЛ**

	Сонсгол, хараа бууралт, алдалт
	Зүрх судасны эмгэг, таргалалт (Артерийн даралт ихсэх өвчин, зүрхний төрөлхийн болон олдмол гажууд г.м)
	Сэтгэцийн эмгэгүүд
	Шүд, эрүү нүүрний эмгэгүүд
	Арьсны халдварт болон халдварт бус эмгэгүүд

**НАРИЙН МЭРГЭЖЛИЙН ЭМЧ НАРЫН НЭГ УДААГИЙН ҮЗЛЭГТ ОНОШЛОХ БОЛОМЖГҮЙ
БУЮУ БАГАЖИЙН ШИНЖИЛГЭЭГЭЭР ОНОШЛОГДДОГ ЭМГЭГҮҮД**

	Уналт таталт
	Сэтгэцийн зарим эмгэг
	Хоол боловсруулах замын дурангаар оношлогддог эмгэгүүд
	Хамар дайвар хөндийн үрэвсэл
	Нурууны эмгэгүүд

Дээрх өвчин, эмгэгүүд нь цэргийн насны залуус, хугацаат цэргийн албан хаагчид, төрийн тусгай албан хаагчид сонгон шалгаруулалтад тэнцэхгүй, албыг хэвийн хааж чадахгүй нөхцөл байдалд хүргэж байна.

Дүгнэлт

Цэргийн байгууллагын анги салбарууд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, дүрмийн бус харьцааг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор дотоод хяналт шалгалтыг байнга явуулж, гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, бие бүрэлдэхүүний ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр тасралтгүй ажил арга хэмжээ зохион байгуулж байгаа боловч хүний амь нас, эрүүл мэнд хохирсон ноцтой гэмт хэрэг, зөрчил гарсаар байна.

Цэргийн анги, байгууллага дахь хүний эрхийн төлөв байдлыг тодорхойлоход цэргийн алба хаагчийн амь нас, эрүүл мэнд хохирсон болон хүнлэг бус харьцсан гэмт хэрэг, зөрчлийг бүртгэх нэгдсэн тогтолцоо чухал үүрэгтэй бөгөөд эдгээрийг нэгтгэн харуулсан мэдээллийн сан одоогоор аль ч байгууллагад байхгүй байгаа нь нөхцөл байдлыг бодитойгоор тодорхойлоход хүндрэл учруулж байна.

Цэргийн байгууллагын анги салбаруудад хугацаат цэргийн алба хаагчдын амь нас, эрүүл мэнд хохирч, амь насаа алдсан гэмт хэргийн улмаас амь эрсэдсэн статистик, мэдээлэлд мэргэжлийн байгууллагуудын гаргасан судалгаа, мэдээлэл болон санал дүгнэлтүүдийг нэгтгэн хяналт, шалгалт хийж, судалгааны үр дүнд үндэслэн дүгнэлтийг тодорхойлсон.

Цэргийн анги, салбаруудад хугацаат цэргийн алба хаагчдаас дүрмийн бус харьцаа, алба хаагчдын харилцаа хандлагыг сайжруулах талаар үүрэг зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийн тайланг авч байгаа боловч түүний мөрөөр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний үр дүн хангалтгүй байна.

Цэргийн анги, салбаруудад хүний амь нас, эрүүл мэнд хохирч байгаа асуудалд хэд хэдэн шалтгаан нөхцөл харагдаж байна.

Дүрмийн бус харилцаанаас үйлдэлтэй гадны нөлөөтэйгөөр, амь нас эрсдэх,

Сэтгэл санааны байдал тогтворгүй байх, стресс бухимдлын түвшин өндөр байх, дасан зохицол, айдас түгшүүртэй байдлаас болж амиа хорлож амь нас эрсдэх.

Хөдөлмөр эрхлэлтийн байдал, /аж ахуйн ажил/ санамсар болгоомжгүйгээс болон хөдөлмөрийн аюулгүй байдал хангагдаагүйн улсаас амь нас эрсдэх.

Хугацаат цэргийн алба хаагчдын эрүүл мэндийн байдал, ужиг суурь өвчлөлтүүд нь байнгын бэлтгэл сургуулилалтын үед ачаалал авч, сэдэрч амь нас эрсдэх, энэ нь нарийн мэргэжлийн эмчийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах нь эрүүл мэндийн үзлэг хийж байгаа ажилчдын нэг хүнд нөөгдөх ачаалал хэт өндөртэй холбоотой гэж үзэж байна.

Мөн хугацаат цэргийн алба хаагчдын эрүүл мэнд хохирч гэмтэж бэртэж байгаа асуудалд дараах нөхцөл байдлуудыг дүгнэн үзэж байна.

Дүрмийн бус харилцаа, мөн хөдөлмөр эрхлэлтийн явцад /аж ахуйн ажил/, байнгын бэлтгэл сургуулилалтын явцад санамсар болгоомжгүйгээс болж эрүүл мэнд хохирч гэмтэж бэртэж байна.

Хугацаат цэргийн алба хаагчдын хөдөлмөр эрхлэлтийн харилцааг Цэргийн нийтлэг дүрмээр зохицуулах ёсгүй харагдаж байна.

Дүрмийн бус харилцааг дэлгэрүүлэн авч үзэх нь тухайн төрлийн дүрмийн бус харьцааг илрүүлэх, урьдчилан сэргийлэхэд ач холбогдолтой.

Санал

Хугацаат цэргийн албанд татагдан ирсэн иргэдийг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулж, нарын мэргэжлийн эмч нарын орон тоог нэмэгдүүлж, эрүүл мэндийн үзлэгийг чанаржуулж, цэргийн албан хаагч болгох.

Цэргийн анги байгууллагуудын төсвийн тооцооллыг нэмэгдүүлэх.

Хугацаат цэргийн алба хаагчдын эрх үүргийг зааглаж, хуульчилж өгөх.

Хугацаат цэргийн алба хаагчдын хөдөлмөр эрхлэлтийн хуульчилж өгөх.

Ерөнхий боловсролын 10 жилийн сурагч байхаас эхлүүлэн цэрэгжлийн хичээлийг заах, цэрэгжлийн спортын арга хэмжээг нэмэгдүүлж, зохион байгуулах.

Хугацаат цэргийн алба хаагчдын насны /18-27 нас/ иргэдийн сэтгэл зүйн болон нийгэм соёлын онцлог биеийн хөгжил, суурь өвчин эмгэг зэргийг нарийвчлан судалж, тохирох сургалт, бэлтгэлжилт, тэсвэр хатуужлыг олгох, цэргийн ажил хөдөлмөрт сургаж хөдөлмөр эрхлүүлэх зэрэг саналтай байна.

Ашигласан материал

А. Эрх зүйн актууд

1. Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 1992. №1.
2. Цэргийн албаны тухай хууль Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2016. №1.
3. Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2016. №1.

В. Ном сурах бичиг, бусад гарын авлага, судалгааны ажил

1. Хүний эрхийн Үндэсний Комисс. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэл. УБ., 2022.
2. Хууль зүйн үндэсний хүрээлэн, Цэргийн алба хаагч хоорондын дүрмийн бус харьцааны нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ. УБ, 2022 он
3. Хууль зүйн үндэсний хүрээлэн, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ судалгааны тайланд хийсэн дүн шинжилгээний нэгтгэл. УБ, 2021 он
4. Цэргийн сахилгын дүрэм
5. ХЭҮК, УЕПГ, “Цэргийн анги байгууллагад үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөлд хийсэн дүн шинжилгээ”